



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

---

**ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ТАЙЛАН**  
**/2020 оны II улирал/**

---

**ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ  
ТАЙЛАН**

/2020 оны II улирал/


Хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэгч нийт 12 банкнаас 2020 оны II улирлын байдлаар гаргасан тайланг нэгтгэн, хэрэглэгчийн тоо ба гүйлгээний дүнг интернэт болон мобайл хандалтын төрлөөр ангилан өмнөх он ба улиралтай харьцуулан авч үзлээ.

**1. ИНТЕРНЭТ ХАНДАЛТ<sup>1</sup>**

**• Хэрэглэгчийн тоо**

Хөдөлгөөнт банкны 2020 оны II улирлын тайлангийн дүнгээр улсын хэмжээнд нийт 2.4 сая интернэт хандалтын эрхтэй хэрэглэгч байгаа нь өмнөх оны II улиралтай харьцуулахад 2.7 мянган хэрэглэгчээр буюу 1.7 хувиар өссөн байна. Шинээр 119.6 мянган хэрэглэгч хот суурин газарт бүртгүүлсэн байна (Хүснэгт 1а). Зураг 1-т интернэт хандалтын эрх бүхий хэрэглэгчдийг хот, аймгаар тус тусад нь авч үзвэл 2020 оны II улирлын байдлаар 75.8 хувийг хот суурин газар, үлдсэн 24.2 хувийг орон нутгийн хэрэглэгчид эзэлж байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад нийт бүртгэлтэй хэрэглэгчдэд эзлэх орон

нутгийн хэрэглэгчдийн хувь 22.3 байснаас 24.2 хувь болж өсжээ.



Тус үйлчилгээгээр сард 3 ба түүнээс дээш удаа гүйлгээ хийж, интернэт банкыг идэвхтэй ашиглаж байгаа нийт 985.6 мянган хэрэглэгч байгаа нь өмнөх онтой харьцуулахад 25.7 мянгаар буюу 2.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд шинээр интернэт хандалтын эрх авахаар 163 мянган хэрэглэгч бүртгүүлсэн нь өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 2.7 мянган хэрэглэгчээр буюу 1.2 хувиар өссөн байна (Хүснэгт 1б).

<sup>1</sup> Интернэт протокол ашиглан хөдөлгөөнт банкны үйлчилгээ авах

• Гүйлгээний тоо, дүн

Тайлант хугацаанд интернэт хандалтаар нийт 25.9 их наяд төгрөгийн 61.6 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны II улирлаас дүнгийн хувьд 3.1 их наяд төгрөгөөр буурсан, тооны хувьд 8.9 сая ширхэг гүйлгээгээр өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт 2б). Тус гүйлгээг үйлчилгээний төрлөөр ангилбал:

- Цахим хуудас – 10.9 их наяд төгрөгийн 6.7 сая ширхэг;
- Гар утасны аппликэйшн – 15 их наяд төгрөгийн 54.8 сая ширхэг гүйлгээ тус тус хийгдсэн байна (Хүснэгт 2а).



Нийт интернэт хандалтаар хийгдсэн гүйлгээний төрлөөр эзлэх хувийг Зураг 2-т үзүүлэв.

2. МОБАЙЛ ХАНДАЛТ<sup>2</sup>



• Хэрэглэгчийн тоо

Хөдөлгөөнт банкны 2020 оны II улирлын тайлангийн дүнгээр улсын хэмжээнд 1.3 сая мобайл хандалтын эрхтэй хэрэглэгч бүртгэгдсэн нь өмнөх оны II улиралтай харьцуулахад 97.1 мянган хэрэглэгчээр буурсан. Тус үйлчилгээг 2020 оны II улирлын байдлаар 532.4 мянган хэрэглэгч идэвхтэй ашиглаж байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс 198.4 мянга буюу 27.2 хувиар буурсан байна. Мобайл банкны хэрэглэгчдийн тоо эрс буурсан байгаа нь тайлангийн загварын шинчлэлтэй холбоотойгоор

<sup>2</sup> USSD, SMS зэрэг үүрэн холбооны технологи ашиглан хөдөлгөөнт банкны үйлчилгээ авах

давхар бүртгэдэг байсныг нарийвчлан бүртгэдэг болсонтой холбоотой юм (Зураг 3). Мобайл хандалтын эрх бүхий хэрэглэгчдийг хот, аймгаар тус бүрээр авч үзвэл II улирлын байдлаар 56.6 хувийг хот суурин газар, үлдсэн 43.4 хувийг орон нутгийн хэрэглэгчид эзэлж байгааг Зураг 1-т үзүүлэв. Тайлант хугацаанд шинээр мобайл хандалтын эрх авахаар 78.5 мянган хэрэглэгч бүртгүүлснээс 78.5 мянга буюу 41.5 хувь нь орон нутагт бүртгэлтэй байна (Хүснэгт 1а).

• **Гүйлгээний тоо, дүн**

Тайлант хугацаанд мобайл хандалтаар нийт 3.2 их наяд төгрөгийн 28.2 сая ширхэг гүйлгээ хийгдсэнийг үйлчилгээний төрлөөр ангилан Хүснэгт 9а-д үзүүлэв. Гүйлгээний тоо, дүнг өмнөх оны II улиралтай харьцуулж үзэхэд гүйлгээний тооны хувьд 21.3 хувиар буюу 5 сая ширхэг гүйлгээгээр өссөн бол, дүнгийн хувьд 1 хувиар буюу 32.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 2б). Мобайл хандалтаар хийгдсэн гүйлгээний дөрвөн жилийн үзүүлэлтийг Зураг 4-т үзүүлэв.



**3. ТЕЛЕФОН БАНК<sup>3</sup>**

• **Хэрэглэгчийн тоо**

Хөдөлгөөнт банкны 2020 оны II улирлын тайлангийн дүнгээр улсын хэмжээнд нийт 380 мянга телефон банкны эрхтэй хэрэглэгч байна. Үүнээс 22.5 мянган хэрэглэгч тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн байна. Телефон банкны эрх бүхий хэрэглэгчдийг хот, аймгаар тус тусад нь авч үзвэл 2020 оны II улирлын байдлаар 50.9 хувийг хот суурин газар, үлдсэн 49.1 хувийг орон нутгийн хэрэглэгчид эзэлж байна (Хүснэгт 1а).

<sup>3</sup> Тусгай дугаарт холбогдон хөдөлгөөнт банкны үйлчилгээ авах

- **Гүйлгээний тоо, дүн**

Тайлант хугацаанд телефон банкаар нийт 51 тэрбум төгрөгийн 252 мянган ширхэг гүйлгээ хийгджээ (Хүснэгт 2а).

**Гэрээт хамтрагч**

Улсын хэмжээнд нийт 631 гэрээт хамтрагч үйл ажиллагаа явуулж байна. Хотуудын хувьд үүнээс 509 буюу 80.7 хувь нь Улаанбаатарт, 7 нь Дарханд, 1 нь Эрдэнэт-д, харин бусад орон нутгаар 114 гэрээт хамтрагч хөдөлгөөнт банкны үйлчилгээг ашиглан өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулж байна (Хүснэгт 3).

**Залилангийн гүйлгээ**

Тайлант хугацаанд хөдөлгөөнт банкны төрлүүдээс зөвхөн Интернэт хандалтаар нийт 63 удаагийн үйлдлээр 17.5 сая төгрөгийн залилангийн гүйлгээ, 72 удаагийн үйлдлээр 90.7 сая төгрөгийн хулгайн гүйлгээ хийгджээ (Хүснэгт 4).

II. ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ТАЙЛАН

Хүснэгт 1а. Хөдөлгөөнт банкны хэрэглэгчийн тайлан - Хот, аймаг

01/04/2020 - 30/06/2020

№	Хот, аймаг	Интернэт хандалт			Мобайл хандалт			Телефон банк			Нийт бүртгэлтэй цахим хэрэглэгч
		Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	
1	Улаанбаатар	109,580.00	1,668,427.00	669,184.00	41,253.00	645,107.00	233,245.00	11,573.00	178,275.00	2,639.00	2,491,809
2	Дархан-Уул	4,941.00	77,730.00	30,732.00	2,231.00	48,475.00	22,424.00	436.00	6,841.00	376.00	133,046
3	Орхон	5,064.00	65,054.00	28,007.00	2,461.00	44,836.00	18,538.00	491.00	8,435.00	189.00	118,325
Нийт (дээрх хотууд)		119,585	1,811,211	727,923	45,945	738,418	274,207	12,500	193,551	3,204	2,743,180
Нийт эзлэх %		73.37%	75.81%	73.86%	58.53%	56.62%	51.51%	55.68%	50.93%	15.14%	67.34%
4	Бусад аймаг	43,396.00	577,882.00	257,623.00	32,554.00	565,833.00	258,151.00	9,948.00	186,469.00	17,958.00	1,330,184
Нийт эзлэх %		26.63%	24.19%	26.14%	41.47%	43.38%	48.49%	44.32%	49.07%	84.86%	32.66%
Нийт (Улс)		162,981	2,389,093	985,546	78,499	1,304,251	532,358	22,448	380,020	21,162	4,073,364

Хүснэгт 1б. Нийт хэрэглэгчдийн тоо

2019-2020

	Интернэт хандалт			Мобайл хандалт			Телефон банк			Нийт бүртгэлтэй цахим хэрэглэгч
	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	
2019-II улирал	160,301	1,723,096	959,828	85,892	1,401,380	730,793	0	0	0	3,213,996
2020-II улирал	162,981	2,389,093	985,546	78,499	1,304,251	532,358	22,448	380,020	21,162	4,073,364
Өөрчлөлт	2,680	665,997	25,718	-7,393	-97,129	-198,435	22,448	380,020	21,162	859,368
Өөрчлөлт (хувиар)	1.67	38.65	2.68	-8.61	-6.93	-27.15	-	-	-	26.74

Хүснэгт 2а. Хөдөлгөөнт банкны гүйлгээний тайлан - Гүйлгээний төрлөөр

01/04/2020 - 30/06/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Төрөл/суваг	Интернэт хандалт				Мобайл хандалт		Телефон банк		Нийт		
		Цахим хуудас		Гар утасны аппликейшн								
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Банк дотор	3,301.10	6,344.22	42,262.22	11,499.20	27,106.67	3,000.57	251.95	50.58	72,922	20,895	
2	Банк хооронд	1,999.46	3,253.10	11,122.05	3,065.32	847.48	129.94	0.00	0.00	13,969	6,448	
3	Олон улсын гүйлгээ	12.35	491.37	1.48	18.80	0.00	0.00	0.00	0.00	14	510	
4	Картын гүйлгээ	44.07	31.75	174.15	61.61	1.07	0.24	0.00	0.00	219	94	
5	Зээл төлөлт	107.67	69.53	333.33	274.70	98.69	49.72	0.00	0.00	540	394	
6	Төлбөр	Торгуулийн төлбөр	16.11	0.37	3.98	0.09	0.00	0.00	0.00	0.00	20	0
		Татвар төлөлт	83.49	196.63	5.63	0.24	0.00	0.00	0.00	0.00	89	197
		Гаалийн төлбөр	8.26	74.17	3.02	2.43	0.00	0.00	0.00	0.00	11	77
		Даатгал	0.27	0.05	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0	0
		Хэрэглээний төлбөр	642.46	41.44	441.07	11.05	115.59	0.81	0.00	0.00	1,199	53
	Бусад	458.60	3.62	5.28	0.08	0.00	0.00	0.00	0.00	464	4	
7	Хөдөлгөөнт банкны процессор	47.81	427.07	482.72	21.60	0.00	0.00	0.00	0.00	531	449	
8	Нийт	6,722	10,933	54,835	14,955	28,169	3,181	252	51	89,978	29,120	

Хүснэгт 2б. Хөдөлгөөнт банкны гүйлгээний тайлан - Гүйлгээний төрлөөр

01/04/2020 - 30/06/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

	Интернэт хандалт		Мобайл хандалт		Телефон банк	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2019-II улирал	52,683.44	29,016.62	23,215.77	3,213.38	0	0
2020-II улирал	61,556.56	25,888.44	28169.496	3181.28	252	51
Өөрчлөлт	8,873.11	-3,128.18	4,953.73	(32.10)	252	51
Өөрчлөлт (хувиар)	16.84%	-10.78%	21.34%	-1.00%	-	-

Хүснэгт 3. Гэрээт хамтрагчийн тайлан – Хот, аймаг

01/04/2020 - 30/06/2020

Гэрээт хамтрагчийн тоо				Нийт
Улаанбаатар	Дархан-Уул	Орхон	Бусад аймаг	
509	7	1	114	631

Хүснэгт 4. Хулгайн болон хулгайн гүйлгээний тайлан

01/04/2020 - 30/06/2020

	Интернэт хандалт				Мобайл хандалт		Телефон банк		Нийт	
	Цахим хуудас		Гар утасны аппликейшн							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залилангийн гүйлгээ	6	2,719,000	57	14,750,000	0	0	0	0	63	17,469,000
Хулгайн гүйлгээ	22	23,898,055	50	66,798,940	1	900,000	0	0	73	91,596,995